

Санхүүгийн зохицуулах хорооны 2025
оныдугаар сарын ...-ны өдрийн
.... дугаар тогтоолын хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашиг хуваарилах, тайлагнах, түүнд хяналт тавихтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР.НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ АЖИЛЛАГАА

2.1.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэх бөгөөд тус шийдвэрт Компанийн тухай хуулийн 46.1-д зааснаас гадна дараах мэдээллийг заавал тусгана:

2.1.1.компанийн нийт хуваарилах ногдол ашиг;

2.1.2.ногдол ашиг хуваарилах хэлбэр;

2.2.Ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хуваарилж шийдвэрлэнэ.

2.3.Давуу эрхийн болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь арилжааны банк дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авахаар хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг тус дансанд байршуулна.

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

3.1.Нээлттэй хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор ногдол ашиг хуваарилалтын тайланг Хороонд ирүүлэх ба тайланд дараах мэдээллийг заавал тусгана:

3.1.1.хувьцааны тоо, ширхэг;

3.1.2.нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;

3.1.3.ногдол ашгийн нийт дүн;

3.1.4.ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн компанийн эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар;

3.1.5.ногдол ашиг төлж эхэлсэн болон дууссан огноо;

3.1.6.ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар дамжуулан хуваарилах гэрээний огноо, дугаар;

3.1.7.олгогдоогүй ногдол ашгийн үлдэгдэл;

3.1.8.хувьцаа эзэмшигчдийн тоо.

3.2.Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь хувьцаат компанитай ногдол ашиг хуваарилах гэрээ байгуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор хувьцаа эзэмшигчид болон үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдэд ногдол ашгийн талаарх мэдээллийг хүргэж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тус Хороонд мэдэгдэнэ.

3.3.Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээлэл ирсэн даруйд холбогдох мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд ажлын 5 өдрийн дотор мэдээлнэ.

~o0o~

